



Шинжээчийн тайлан

Байгууллагын нэр: Эм зүйн шинжлэх ухааны их сургууль

Хөтөлбөрийн нэр: “Эм зүй” бакалаврын хөтөлбөр

Индекс: D091601

Шинжээчийн баг:

Ахлагч: Г.Чойжамц

Гишүүд: С.Гаадулам

С.Аюурбуниа

2020 оны 10-р сарын 27-28

Агуулга

Товчилсон үгийн тайлбар	4
I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт	5
II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга	6
III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт	7
Шалгуур1: Хөтөлбөрийн төлөвлөлт	7
Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа	9
Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	12
Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	15
Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	19
Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа	26
Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажилт	28
IV. Уулзалтад оролцогчдын нэрс	35
I. Багш нарын нэрс	35
II. Оюутнуудын нэрс	35
III. Ажил олгогчдын нэрс	36
IV. Төгсөгчдийн нэрс	36
V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал	37
VI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр	38
VII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр	39

Товчилсон үгийн тайлбар

МУ	Монгол улс
БСШУСЯ	Боловсрол соёл шинжлэх ухаан спортын яам
БСШУС	Боловсрол соёл шинжлэх ухааны сайд
БМИҮЗ	Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний
зөвлөл	
МУҮНС	Монгол Улсын Үндэсний Номын Сан
СХД	Сонгинохайрхан дүүрэг
СБД	Сүхбаатар дүүрэг
ИС	Их сургууль
АШУУИС	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль
ЭЗШУИС	Эм зүйн шинжлэх ухааны их сургууль
ЕС	Ерөнхий суурь
МС	Мэргэжлийн суурь
МШ	Мэргэшүүлэх
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
CU	Cloud University (Үүлэн тооцоолуур)
НДБЭБ	Номхон далайн баруун эргийн бүс
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЭЭШ	Элсэлтийн ерөнхий шалгалт
ЭШС	Эрдэм шинжилгээ судалгаа
АУИС	Анагаах ухааны их сургууль
МОХ	Монголын оюутны холбоо
МЗХ	Монголын залуучуудын холбоо
ОУ	Олон улсын
МЭИК	Монгол эм импекс концерн
УГТЭ	Улсын гуравдугаар төв эмнэлэг
ХОН	Хөдөө орон нутаг
ЭХНБ	Эм ханган нийлүүлэх байгууллага
ЭЗИС	Эм зүйн их сургууль
АУИС	Анагаах ухааны их сургууль
МЭЗБН	Монголын эм зүйн байгууллагуудын нэгдсэн
ЭЗШУА	Эм зүйн шинжлэх ухааны академи

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

Сургуулийн нэр /Монгол, Англи/	Эм зүйн шинжлэх ухааны их сургууль Mongolian University of Pharmaceutical Sciences		
Сургалтын хөтөлбөрийн нэр	“Эм зүй” бакалаврын хөтөлбөр		
Индекс	D091601		
Шинжээчид	1. Г.Чойжамц – Оточ Манрамба Их Сургуулийн Эрдэм шинжилгээ эрхэлсэн дэд захирал 2. С.Гаадулам – Этүгэн Их Сургуулийн Анагаах Ухааны Сургуулийн Эм зүй салбарын багш 3. С.Аюурбуниа – Азифарма Эм Ханган Нийлүүлэх Байгууллагын менежер		
Зохицуулагч	Б.Мядагмаа – Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн Ажлын албаны Магадлан итгэмжлэл хариуцсан шинжээч		
	Хугацаа	Хийгдсэн байх ажлууд	
Төлөвлөгөө	2020 оны 10 сарын 27 өдөр		
	09:00-10:00	Зохицуулагч шинжээчийн багийг танилцуулна	
		Шинжээчийн багийн ахлагч үг хэлнэ: Магадлан итгэмжлэлийн үйл явц, хуваарийг танилцуулах	
		Сургуулийн захирал үг хэлнэ	
		Удирдлага болон ӨҮ-гийн багтай уулзах: Өөрийн үнэлгээний багийн бэлдсэн хөтөлбөрийн товч танилцуулга	
	10:00-13:00	Сургуулийн бэлтгэсэн материал, илрэл нотолгоотой танилцах	
	13:00-14:00	Цайны завсарлага	
	13:00-14:00	Оюутнуудтай хийх уулзалт	
	14:00-15:00	Багш нартай хийх уулзалт	
	15:00-16:00	Өөрийн үнэлгээний тайлангийн нотлох баримттай танилцах	
	2020 оны 10 сарын 28 өдөр		
	10:00-11:00	Тайлантай холбоотой нотлох баримттай танилцах, холбогдох багш нараас тодруулга, лавлагаа авах	
	11:00-13:00	Ажил олгогчидтой хийх уулзалт	
		Төгсөгчидтэй хийх уулзалт	
	13:00-14:00	Цайны завсарлага	
	14:00-15:00	Тайлантай холбоотой нотлох баримттай танилцах, холбогдох хүмүүсээс тодруулга, лавлагаа авах	
15:00-16:30	Шинжээчид дүгнэлтээ хэлэлцэн, гаргана. Нэмэлт материал үзэх танилцах		
	Шинжээчдийн баг магадлан итгэмжлэлийн эцсийн шийдвэрийг бус, урьдчилсан дүгнэлтийг байгууллагад мэдэгдэнэ.		
Шалгуур шаардлага /журам/	БМИҮЗ-ийн Удирдах зөвлөлийн 2018 оны 06-р сарын 26-ны өдрийн 08 тоот тогтоолоор батлагдсан “Боловсролын магадлан итгэмжлэх үйл ажиллагааны журам”, “Сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн нийтлэг шалгуур, шаардлага”-ын дагуу ажиллав.		

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

ЭЗШУИС нь анх “Монос” коллеж нэртэйгээр 2000 онд үүсэн байгуулагдаж, өнөөг хүртэл эм зүйн хөтөлбөрөөр 21 удаагийн элсэлт авч, нийт 16 удаа төгсөлт хийж, 1618 эм зүйч мэргэжилтэнг бэлтгэн гаргасан.

Он цагийн хэлхээс:

- 2000 онд “Монос” коллеж
- 2004 онд “Монос” дээд сургууль
- 2015 онд *Эм Зүйн Шинжлэх Ухааны Их Сургууль болсон.*

Магадлан итгэмжлэл: 2015 онд Эм зүй хөтөлбөрийг анх удаа магадлан итгэмжлүүлж, 2020 онд хоёр дахь шатанд магадлан итгэмжлүүлэх хүсэлт гаргасан.

Үндсэн багшийн тоо: 2020-2021 оны хичээлийн жилд 65.

Эрдмийн зэрэг цолтой багшийн эзлэх хувь: 2020-2021 оны хичээлийн жилд 39 хувь (Үүнээс: Академич 5, Шинжлэх ухааны доктор 2, Доктор 18).

Суралцагч оюутны тоо: 2020-2021 оны хичээлийн жилд **1032** оюутан, суралцагч эм зүй хөтөлбөрөөр суралцаж байна.

Хөтөлбөрийн шинэчлэн сайжруулалт:

ЭЗШУИС нь Эм зүй хөтөлбөрийг шинэчлэн сайжруулах, улам боловсронгуй болгох талаар өмнөх магадлан итгэмжлэл ба 2015 оноос хойш нийтдээ их сургуулийн дэргэдэх эрдмийн зөвлөлийн хурлаар 1 удаа, хөтөлбөрийн ерөнхий хороогоор 3 удаа (2015-2016, 2017-2018, 2018-2019), дэд хороодоор 33 удаа (2015-2016, 2017-2018, 2018-2019, 2019-2020) тус тус хэлэлцүүлсэн.

II. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

Илрэл нотолгоо:

1. Даяаршлыг дурьдаад Олон улсын Эм зүйчдийн холбооны сүүлийн үед хийсэн хэд хэдэн хурлын тунхаг бичигт “Эм зүйчийн өв тэгш дүр төрх”, “Эм зүйчийн хандлага”, “Өвчтөнд ээлтэй тусламж үйлчилгээ үзүүлэх тухай онцолсныг, 2016 онтой харьцуулбал **олон улсад эмийн зах зээлд ажиллагсад 6, Монголд 14,3 хувиар** өсч байгааг тэмдэглэсэн
2. Монголд 10000 хүн амд ногдох эм зүйч **орон нутагт 3,8 хот сууринд 10,5 /дундаж 6,8/ 1 эм зүйчид** ногдох хүн амын тоо хөдөөд **2630**, хотод **952 /дундаж 1462/** 2018 оны байдлаар улсын хэмжээнд Эмийн үйлдвэр 47, ЭХНБ 437, Эмийн сан 2175 байна. ЭХБ-ын улсын стандартыг авч үзвэл мэргэжилтний хангамж **49,5** хувь байгаа нь мэргэжилтэн бэлтгэх хэрэгцээ өндөр байна гэдгийг тогтоосон
3. Үндэсний хэмжээнд Эм зүйч бэлтгэдэг сургуулиуд 5 байгаа бөгөөд 2013-2018 оны мэдээгээр ЭЗШУИС-иар бэлтгэгдсэн мэргэжилтний тоо /93-131/ хамгийн өндөр нийт төгсөгчдийн **45** хувь бөгөөд ойрын 15 жилд эм зүйчийн хэрэгцээ буурахгүй гэж төсөөлсөн нь үнэмшилтэй
4. ЭЗШУИС -ын Эрхэм зорилго: **“Даяаршлын үйл явц, Монгол орны хэрэгцээ шаардлагад нийцсэн мэдлэг, ур чадвар, зөв төлөвшилтэй, мэргэжилтэн бэлтгэж, төгсөгчдийг тасралтгүй сургалтаар хөгжүүлэн тэдний амьдралын чанарыг сайжруулагч, сургалт-эрдэм судалгаа- үйлдвэрлэл хосолсон энтерпренер сургууль байна”**
5. Алсын хараа: **“Үндэсний шилдэг, Азийн бүсэд хүлээн зөвшөөрөгдсөн сургууль байна”**

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн зорилго нь төрөөс боловсролын талаар тавьж байгаа зорилтод нийцсэн, оролцогч талуудын хэрэгцээ шаардлагыг хангахад чиглэж байна
- Монгол улсад ойрын ирээдүйд Эм зүйч бэлтгэх хэрэгцээ мэргэжилтний эрэлт өндөр байна
- Манай оронд эдүгээ Эм зүйч бакалавр бэлтгэдэг 5 сургууль байгаа боловч тус сургуулийн төгсөгчид 45 хувь орчмыг эзлэж байна

Зөвлөмж:

- Ойрын ирээдүйд тус сургуулийн төгсөгчид Монгол улсын эм хангамжийн салбарт ажиллагсдын дийлэнх болох төлөвтэй байгаа нь төгсөгчдөд тавигдах чанарын

шаардлагыг ихээхэн нэмэгдүүлж байгаа төдийгүй хөрвөх чадвартай төгсөгчид бэлтгэх хэрэгцээ үүсч байгааг онцлон анхаарч мэргэжилтний загварыг улсын хэмжээнд авч үзэж хөтөлбөрийг улам боловсронгуй болгох

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

1.2 Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

Илрэл нотолгоо:

1. Хөтөлбөрийн зорилго

- “Их сургуулийн онцлог давуу тал, нөөц бололцоонд түшиглэн, эрүүл мэнд, боловсролын талаар төрөөс баримтлах бодлого, нийгмийн хэрэгцээ шаардлагыг бүх талаараа хангасан эм зүйчдийг бэлтгэн гаргана” хэмээн тодорхойлсон

2. Оролцогч талуудын хэрэгцээ шаардлагыг судалсан тухай нотлох баримт:

- а. Тус сургуулийн 15 удаагийн төгсөлтөөр 1374 эм зүйч бэлтгэн гаргасны 93,2 хувь мэргэжлээрээ ажиллаж байгаа бөгөөд ажил олгогчдоос жил бүр судалгаа авдаг болсон, өөрийн үнэлгээний тайланд бичсэнээр 60 хувь нь хамрагдаж байгаа ажээ.
- б. Тайланд БСШУСЯ-аас ... үр дүнд суурилсан боловсролын тогтолцоо нэвтрүүлэх зорилт тавьж буйг хэрэгжүүлэхэд ажил олгогчидтой хамтран ажиллаж хөтөлбөрийн хөгжлийг анхаарч байгааг дурьдан тэмдэглэсэн бөгөөд тайлангийн х.17-д Хүснэгт 5-аар ажил олгогчдын тавьж буй нийтлэг шаардлага Зураг 6, хэрэгжилтийн судалгааг Хүснэгт 6, 7-оор,
- с. Төгсөгчдийн үнэлгээг /нотолсон 9 томоохон бодитой ажил хийж сургалтад төдийгүй үйлдвэрлэлд нэвтрүүлсэн/ Хүснэгт 7 ба Зураг 7-оор харьцуулалтыг тус тус судлан сүүлийн 5 жилээр харуулсан нотлох баримтаар баталгаажиж байна.

Онцлог зүйл/Туршлага:

- Нийгмийн хэрэгцээ шаардлагыг судлаж Эм зүйч мэргэжилтнийг ажилд авах нийтлэг шалгуур тогтоосон

Зөвлөмж:

- Хөтөлбөрийн зарилгод “... **Нийгмийн хэрэгцээ шаардлагыг бүх талаараа хангасан эм зүйчдийг бэлтгэн гаргана**” гэсэн боловч ерөнхийдөө Эмнэл зүйн эм зүйч бэлтгэж байна цаашид эмийн химич, эмийн технологич, биотехнологч бэлтгэх шаталсан сургалтын бодлого боловсруулж хэрэгжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэх

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

1. Сургалтын төлөвлөгөөний агуулгыг эх орны Эм зүйч мэргэжилтэн бэлтгэдэг бусад сургуулиуд /Эм зүй Индекс 091601/ ба Эм зүйчийн мэргэжлийн боловсролын улсын стандарт /MNS5323-126:2012/-тай харьцуулан анализ хийж: Багц цагаар илэрхийлэгдэх агуулгын хувьд - улсын стандартад хүрсэн, АШУҮИС болон Номхон далайн баруун эргийн бүсийн /НДБЭБ/ зарим орны их, дээд сургуулиудтай /БНХАУ, БНСУ, Сингапур/ ойролцоо болсныг тогтоосон.
2. Сургалтын төлөвлөгөөний агуулгыг авч үзсэн дүгнэлтэд: Ерөнхий суурь ба Мэргэшүүлэх хичээл бусад сургуулийнхаас ЭЗШУИС хамгийн өндөр энэ дарааллаар 23,5 ба 44,7 хувь, Мэргэжлийн суурь ба Сонгон судлах хичээл бусад сургуулиас /34,5-45,7 ба 4,9-11,5/ хамгийн бага дээрх дарааллаар 22,3 ба 4,5 хувь байгааг өөрийн үнэлгээний тайланд тэмдэглээд БСШУ сайдын 2014 оны А/174 тоот тушаалын хавсралтын 2,2,1 дэх заалт 30:25:45 байх гэсэн нийтлэг шаардлагыг хангасан гэж үзсэн ба түшиглэсэн байгууллага Монос группын олгосон өргөн боломж сургалтын сайн баазад суурилсан үйлдвэрлэлийн ба мэргэшүүлэх дадлагад илүү анхаарч төлөвлөснийг бусад сургуулиудаас хөтөлбөрийн ялгарах агуулга хэмээн дүгнэлээ.
3. НДБЭБ нутгийн дээр дурьдан харьцуулсан их сургуулиудын эм зүйч бэлтгэдэг сургалтын төлөвлөгөөтэй харьцуулсан анализыг бас харуулж зохих дүгнэлт хийсэн гэж үзлээ
4. ЭЗШУИС-ийн Эм зүйч бэлтгэдэг хөтөлбөр нь “Үр дүнд суурилсан боловсрол” олгох зорилтын хүрээнд ур чадвар, дадлага /тайланд гардан, урлан хэмээн тэмдэглэсэн/ олгоход илүү анхаарч буйг онцолсон.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэх сургалтын нөөц бүрдүүлж чадсан байна

Зөвлөмж:

- Багшлах эрдмийн цолтой багш нарын эзлэх хувийг нэмэгдүүлэх

1-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

Илрэл нотолгоо:

- Тус сургууль сургалтын төлөвлөгөөг 2015, 2018, 2019 онд сайжруулж хөтөлбөрийг шинэчилсэн Сургалтын төлөвлөгөөний агуулгын харьцааг 1,2-т тодорхой бичсэнийг харна уу. Хөтөлбөрийн төлөвлөлтийн талаар Өөрийн үнэлгээний тайлангийн 27-28 дахь талд SWOT, TOWS үнэлгээний үр дүнгээ харуулсан нь нотлох баримтаар баталгаажиж байна.

- Тухайлбал 2015-2016 онд уламжлалт ба оюутан төвтэй идэвхтэй сургалтын аргыг хослуулахын тулд **ЕС 24, МС 27, МШ хичээл 49 хувь нийт 175 багц** багийн сургалт явуулахаар 2019-2020 оноос ... сургалтын үйл ажиллагааг чанаржуулах, суралцагчийн сурах үйлийг дэмжих, багшлах хүний нөөцийн чадамжийг дээшлүүлэх, сургалтын үр дүнг үнэлэн дүгнэх, заавал эзэмших цогц чадамжийг мэргэжлийн ба мэргэшүүлэх хичээлүүдэд мөрдүүлэхээр **ЕС 26, МС 25, МШ хичээл 49 хувь нийт багц цаг 179** болгожээ.
- ЭЗШУИС-ийн сургалтын хөтөлбөр нь суралцахуйн /CLO/ ба хөтөлбөрийн /PLO/ үр дүнгийн нийтлэг шаардлагыг хангасан мэргэжилтэн бэлтгэхэд чиглэсэн хүний эрүүл мэндийг хамгаалахад чиглэсэн зөв бие хүн бэлтгэх 8 од /өмнө нь 7 одтой байсныг хөгжүүлж/ бүхий цогц чадамжтай эм зүйч байна гээд одоогийн хөтөлбөрөөр суралцагчдын ирээдүйд эзэмших цогц чадамж /PEO/ийг Зураг 11-р харуулжээ.
- Сургалтын арга зүй нь: Оюутан төвтэй, тэдний бие даах үйл ажиллагааг дэмжихэд чиглэсэн асуудалд, нөхцөлд, сорилтод, төсөлд, түүхт, туршилтад ба идэвхжүүлэлтэд суурилсан
- Сургалтын үнэлгээний хэлбэр нь Суралцагчийн мэдлэг, чадвар, хандлагыг багаар ажиллах, дүрд тоглох, мэтгэлцэх, бие биедээ заах, багаар заах ба эвлүүлэгийн, галлейргаар тойрох тонгоруу аргаар явуулдаг гэж ӨҮ-ний тайланд тэмдэглэжээ.
- Оролцогч ба сонирхогч талуудын санал зөвлөмжийг хөтөлбөрийн шинэчлэлд тусгах талаар хийж буй үйл ажиллагааны талаарх тайлан нотолгоог 2,1-д тодорхой бичснийг харна уу.

Онцлог зүйл/Туршлага

- Хөтөлбөрийн агуулга нь Монгол улсын стандартын шаардлагыг хангаж байна
- ЭЗШУИС-ийн сургалтын хөтөлбөр нь суралцахуйн /CLO/ ба хөтөлбөрийн /PLO/ үр дүнгийн нийтлэг шаардлагыг хангасан мэргэжилтэн бэлтгэхэд чиглэсэн хүний эрүүл мэндийг хамгаалахад чиглэсэн зөв бие хүн бэлтгэх 8 од /өмнө нь 7 одтой байсныг хөгжүүлж/ бүхий цогц чадамжтай эм зүйч бэлтгэхээр одоогийн хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж байна

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Өөрийн хөтөлбөрийн гол онцлог болсон 8 од бүхий цогц чадамжтай мэргэжилтэн бэлтгэх зорилтоо сайтар хөгжүүлэн, үлгэр жишээч үйл ажиллагаа явуулах

2.2 Сургалтын арга зүй

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

Илрэл нотолгоо:

1. Хөтөлбөрийн зорилгыг хичээл тус бүрийн суралцахуйн үр дүнд суурилсан, сургалтын арга зүйд тулгуурласан, идэвхтэй арга зүйг нэвтрүүлэхийг зорьж хичээлийн хөтөлбөрөөр тодорхойлсон матриц /Зураг 12/ боловсруулсан. Үүний үр дүнг тус сургууль 2015- 2019 онд төгсөгчдийн лицензийн шалгалтын үр дүнгээр үнэлэн х.32-т Зураг 13-р /97-100хувь/ харуулсан.
2. ЕС /24-30,МС/2-6/ ба МШ /2-6/ хичээл тус бүр дээр сонгон суралцах хичээлтэй болгож оюутны сонгон суралцах хичээлийн оролцоог х.34-т Зураг 15-аар харуулсан нь нотлох баримтаар нотлогдож байна

3. Танхимын /3824-4144/ ба танхимын бус /3178-4432/ сургалтын харьцааг 2015-2019 оноор харьцуулан судалж /Хүснэгт 10/, практик сургалт дадлагын хугацааг нэмэгдүүлж үр чадвар олгоход чиглэсэн гэж үзлээ.
4. ЭЗШУИС өөрийн Эм зүйн хөтөлбөрийн уялдаа холбоог судлан анализ хийж х.36-д зураглалаар харуулсан байна. Хичээл хооронд уялдаатай, агуулга нэг хичээлээс нөгөөд залгамжилсан, курсээс курсэд шат ахиж гүнзгийрсэн, суралцагчдад хөгжих боломж олгосон байна гэж үнэлэх боломжтой.
5. Танхимын ба танхимын бус хичээлийн цагийн хуваарь Хүснэгт 11 ба Зураг 16-д харуулсантайгаа нотлох баримтууд нийцэж, тохирч байна
6. Суралцагчийн танхимын хичээлийн цагийн ачаалал 2019 оноос 8,5-30 цаг/7 хоног болгож бие даах цагийн нөөцийг 2015 ба 2018 оныхоос тус бүр 1 буюу суралцах хугацаандаа 200 орчим цагаар арвижуулсан.
7. Үйлдвэрлэлийн /Эмийн сангийн, ЭХНБ-ын, Эмийн ургамлын, Эмийн сангийн технологийн ба эмийн үйлдвэрийн, Эм зүйн албаны ба Мэргэшүүлэх/ дадлагад 6 удаа гарч танхимд олгосон онолын мэдлэгээ бататгах боломжтой болгож хөтөлбөрөө хөгжүүлсэн тухай Зураг 16 –аар харуулсан Хөтөлбөрийн модны уялдаа, залгамж холбоо онол, дадлагын хичээлийн бааз, онол дадлага удирддаг багш гэх мэт харилцан хамаарал нь холбогдох баримтаар нотлогдож байна.

Онцлог зүйл/Туршлага:

- Онолын хичээл заах багшлах хүн хүчний нөөц бүрдүүлсэн, эрдмийн цол, зэрэгтэй багш нарын тоо өмнөх магадлан итгэмжлэлийн үеэс нэмэгдсэн, тус сургуульд Анагаах ухааны академийн гишүүн 4 багш ажиллаж байна

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Эрдмийн зэрэг, цолтой багш нарын тоог улам нэмэгдүүлэх талаар хийж буй ажил үйл ажиллагаа эрчимжүүлэх

2.3 Суралцагчийн үнэлгээ

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

1. Суралцагчдын мэдлэг үнэлэх тогтолцооны талаар тус сургууль дээр хийж буй үйл ажиллагааны ахиц үр дүнг ӨҮТ-ийн 43-51-д Хүснэгт 15-19 ба Зураг 18 ба 19-аар харуулснаас үзвэл Хөтөлбөр нь үр дүнд суурилсан арга зүйд тулгуурлаж буйг ӨҮТ-д тэмдэглээд 2015 онд Суралцагчийн мэдлэг чадварыг үнэлэх журам, Төгсөлтийн шалгалтын журмыг шинэчлэн, цогц чадамж үнэлж дүгнэх аргад шилжин явцын /ирц, хандлага, бие даалт, явц бүгд 60-70 оноо/ ба хөндлөнгийн үнэлгээ /улирлын шалгалт 18-30 оноо/ -ний журам хэрэгжүүлжээ.
2. **Суралцахуйн үр дүнгийн үнэлгээний арга нь:**
 - А. Танин мэдэхүйн түвшин үнэлэх /таньж мэдэх, учрыг ойлгох, хэрэглэх, дүн шинжилгээ хийх, үнэлгээ хийх, бүтээх - 6/
 - Б. Хувь хүний хандлагын түвшин үнэлэх /хүлээн авах, хариу үйлчлэх, ач холбогдол өгөх, цэгцлэх, тодорхойлох гэсэн 5 түвшинтэй/

Үнэлэх хэлбэр нь:
Аман /илтгэх, асуулт хариулт, ярилцлага хийх, мэтгэлцэх гэх 5/,

Бичгийн /тайлан, төсөл, ангийн ажил, реферат, илтгэл, эссе, хариулт бичих, тест зохиох, тохиолдол зохиох буюу шинжлэх, дүгнэлт, тойм бичих гэх 11/ ба

Дадлагаар /Практик туршлага судлах, дагалдан гүйцэтгэх, туршилт хийж гардан гүйцэтгэх, туршилт тавих, багт суурилах, хяналтын уралдаан тэмцээн гэх 6/, **Ажиглаж** /түвшин тогтоох, оношлох, явцын ба эцсийн гэх 4/

3. **Суралцагчидыг үнэлэх үнэлгээний хэлбэр нь:** Мэдлэг, чадвар ABCD /60-100/ ба хандлагыг /3 удаагийн сорилоор/
4. **Шалгалтын хэлбэр нь:** Амаар //26 хичээл, Сорилоор буюу хөндлөнгийн /39 хичээл/
5. **Суралгын амжилт, чанарын үзүүлэлт:** сүүлийн 5 жилээр гаргасан судалгааны дүнгээс үзвэл амжилт 69,8-91 хувь ба Чанар 40,2-65 хувь хүртэл бөгөөд голч үнэлгээ 1,85-2,65 болж тус тус өссөн байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Суралцагчийн мэдлэг, чадвар, цогц чадамж үнэлэж дүгнэх аргад шилжин явцын /ирц, хандлага, бие даалт, явц бүгд 60-70 оноо/ ба хөндлөнгийн үнэлгээ /улирлын шалгалт 18-30 оноо/ -ний журам хэрэгжүүлжээ

2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

3.1.Сургалтын орчин

Сургалт судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

Илрэл нотолгоо:

- Дээд боловсролын тухай хууль, БСШУ-ны сайдын тушаал “Бакалаврын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлага”, “Эм зүйч мэргэжлийн стандарт MNS 5323-126 2012”-ийн шаардлагад нийцсэн сургалтын орчныг иж бүрэн бүрдүүлж, шинэчлэл хийсэн байна. Үүнд:
- Хичээлийн 1-р байрны 4-р давхар, 3,4-р байр, спорт заал барьж ашиглалтанд оруулснаар өөрийн эзэмшлийн 5019,9 м² талбай бүхий 57 өрөөтэй, лекцийн 4 заал, 7 тэнхим, 10 лаборатори, спорт заал, ургамлын музей, эрдмийн өргөө, номын сан бүхий сургалтын зориулалтын 4 байртай, 1400-оюутан хичээллэх, багшийн ажиллах орчин сайжирч, сургалтын хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан орчин бүрдсэн байна
- Оюутны дотуур байрны үйлчилгээний хүртээмжид анхаарч улсын стандартын шаардлагад тохирсон 405 м² дотуур байр болон сургалтын орчны хүрэлцээ, хангамж, эрүүл ахуй, галын аюулгүй байдал, ашиглалтын байдалд анхаарч үр дүн, хийсэн ажлын талаар тайланд тусгасан байна.

Онцлог зүйл/Туршлага:

Хичээлийн 1-р байрны 2-4-р давхрын коридори ханаараа: Монголын эм зүйн эрдэмтдийн, Монголын эмийн ургамлын сан хөмрөгийн, Монголын их хаадын хөрөг зургийг байрлуулсан нь танин мэдэхүйн орчинг бий болгосон байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Анхаарах асуудал:

- Сургалтын орчны оюутанд нөлөөлөх үлгэрч байдал, дууриалалыг бүрдүүлэх талаар анхаарах, анхааруулга, санамжыг олшруулах

Зөвлөмж:

- Хичээлийн төв байрны дотор орчинд шинжлэх ухааны чухал мэдлэг, технологийн дэвшил, багш эрдэмтдийнхээ бүтээлийг харуулсан ханын самбар олныг байршуулах

3.2.Сургалтын хэрэглэгдэхүүн

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Эм зүйч мэргэжлээр сургах сургалтын хэрэглэгдэхүүнийг бүрдүүлэхэд анхаарч лаборатори-6, кабинет-6-г шинээр болон шинэчилэн тохижуулж сургалт явуулдаг болсон бөгөөд сургалтын хэрэглэгдэхүүний жагсаалт, хүртээмж, ашиглалтын талаар сэтгэл ханамжийн судалгаа авч тухай бүрд дүн шинжилгээ хийж анагаахын, мэдээллийн технологийн, гадаад хэлний, эмийн ургамал-эмийн түүхий эд, эмийн технологи, эм судлалын, эмийн шинжилгээний лабораторийн хичээлийн сургалтанд шаардлагатай багаж тоног төхөөрөмжүүдтэй сургалт явуулдаг болсон
- Сургалтын ажлыг зохион байгуулах заавар, удирдамж, зөвлөмж хангалттай
- E- контент төвшинд боловсруулсан
- Сургалтын материал, тоног төхөөрөмж, мэдээллийн технологийн хэрэгсэл, цахим орчны ашиглалт, хүртээмж, сэтгэл ханамжийн судалгаа гарган жил бүрийн төсөвт оруулан хангалт хийдэг
- Сургалтын хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх үйл ажиллагааг амжилттай явуулахад сургуулийнхаа багш оюутныг сургалт судалгаанд оролцох боломжийг бүрдүүлэх, тэдний шинэ санааг дэмжих, хөгжүүлэхэд чиглэсэн “Гарааны гурван хүч”-старт апп компани байгуулсан нь оюутныг мэргэжлийн ур чадвар эзэмших, шинийг сэдэхэд болон багаар хамтран ажиллахад ихээхэн үр нөлөөтэй болжээ.

Онцлог зүйл/Туршлага:

- Багш оюутныг сургалт судалгаанд оролцох боломжийг бүрдүүлэх, тэдний шинэ санааг дэмжих, хөгжүүлэхэд чиглэсэн “Гарааны гурван хүч”-старт апп компани байгуулсан нь оюутныг мэргэжлийн ур чадвар эзэмших, шинийг сэдэхэд болон багаар хамтран ажиллахад үр нөлөөтэй болсон байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Анхаарах асуудал:

- Ажил олгогчдын сонирхолд хэт их ач холбогдол өгч сургалтын агуулгад өөрчлөлт хийхээс болгоомжилж эм зүйн ухааны хөгжлийн чиг хандлагыг ямагт анхаарах

Зөвлөмж:

- Оюутан төгсч гармагц эн тэргүүнд хийж сурсан байхыг шаардах анхан шатны мэдлэг, чадвар, дадлага олгохыг улам илүү чухалчлах

3.3.Номын сан, мэдээлэлийн эх үүсвэр

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Сургуулийн номын сан 300 м² талбайтай, 180 суудалтай, 20186 номтой үүнээс эм зүйн мэргэжлийн хөтөлбөрийн 8291 ном, сурах бичиг, гарын авлага байгаа нь нэг оюутанд ногдох ном, мэргэжлийн ном, сурах бичгийн тоо - стандартын заалттай харьцуулахад тохирч байна.
- Цахим номын сан нь үйлчилгээндээ шинээр "Flipping book " программ ашиглаж байгаа бөгөөд цахим мэдээллийн сан, нээлттэй эх үүсвэрийн ашиглалтыг нэмэгдүүлэх зорилгоор "Дээд боловсролын салбарын цахим нэгдсэн номын сангийн төсөлд" хамрагдсан байна.
- Сургалтын хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцийн хангамж, цахим орчин ашиглалтын талаар, сэтгэл ханамжийн судалгааны дүнгээс харахад 64%-оос дээш үнэлгээтэй байна
- УМС-ийг ашиглахын зэрэгцээ Cloud University /Үүлэн тооцоолуур/ мэдээллийн системийн цогц программыг бүрэн нэвтрүүлснээр их сургуулийн сургалтын бүх үйл ажиллагааг харилцан хамаарал холбоонд нь багш оюутнууд үзэж болох өргөн боломжтой болсон байна.
- Оюутанд цахим сургалт явуулахад Movie Maker, Power Point, Camtasia зэрэг программуудыг ашигласан байна.

Онцлог зүйл/Туршлага:

- Монос группийн хөрөнгө оруулалтын дэмжлэг сайн.
- Номын сангийн үйл ажиллагаа нь оюутанд сурах тааламжтай орчин болсон

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Анхаарах асуудал:

- Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн Фармакопеи - нуудыг сургалтанд ашиглах

Зөвлөмж:

- Сургууль, улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжлийн сурах бичгийн тоог олшруулах

3-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

Илрэл, нотолгоо:

- Хөтөлбөрийн хорооны 32, дэд хорооны 57 удаагийн хурлаар тус сургуулийн эм зүйн ангид ордог бүх хичээлийн хөтөлбөрийг хэлэлцэн баталгаажуулсан хурлын дэлгэрэнгүй протокол, хурлаас гарсан шүүмж зөвлөмжийг тусган зассан тухай холбогдох материал Шалгуур 4-ийн нотлох баримттай танилцаж баталгаажууллаа.
- Хөтөлбөрөө хэрэгжүүлэх цахим удирдлага мэдээллийн тогтолцоо бүрдүүлэн хэрэгжүүлэх хүрээнд тус сургуульд www.sw.xcloud.mn ба www.tw.xcloud.mn гэсэн 2 сайтыг байнгын үйл ажиллагаанд хэрэглэгдэж байна
- Цахим удирдлагын хүрээнд програм хангамжийн шинэчлэлтэд жил бүр 421000 төгрөгийн хөрөнгө оруулалт гаргаж тогтмолжсон байна
- Эм зүйчийн хөтөлбөрийн хэрэгжилтэд зарцуулсан зардал нийт зардлын 79,1 хувь. Нэг оюутанд ногдох зардлыг жигнэсэн дунджийн аргаар тооцсон үзүүлэлтийг ӨҮТ-д тусгасан байна. Нэг хичээлийн жилд нэг оюутанд дунджаар 1,435,571 төгрөг буюу сургалтын төлбөрийн 56 хувьтай тэнцүү үүнээс удирдлагын зардал 200,057 төгрөг ажээ.
- Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлтийн хөтөлбөр боловсруулж хэрэгжилтийг хангах үйл ажиллагааг Монос Улаанбаатар, Ази фарма ба Монголэмимпекс компанитай хамтран суралцагсдын дунд хичээлээс гадуур лекц, сургалт уулзалт, тэмцээн зохион байгуулж төгсөгчдийг ажлын байраар хангах ажлыг амжилттай зохион байгуулдаг юм байна.
- Эм зүйн бакалаврын хөтөлбөрийг орон нутгийн мэргэжлийн байгуулага болон ЕБС-иудын сурагчдын дунд мэргэжлийн багш нар биеэр очих, вэб хуудас ба нүүр номоор зохион байгуулдаг ба сүүлийн 5 жилд 20 мянга гаруй хүүхэд хамрагджээ.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн удирдлага, менежментийн тогтолцоо бүрдсэн үйл ажиллагаа тогтмолжсон
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэх, үр дүнгээ нийтийн хүртээл болгох талаар олон талт үйл ажиллагаа явуулж, мөнгө санхүүгийн шийдэл гаргасан нь тодорхой үр дүнд хүрч байгаа

Анхаарах асуудал:

- Сургуулиа Эм зүйч бэлтгэх улсын хэмжээний анхаарал татсан байгууллага болж байгаа онцлогоо олж харж менежментийн цар хүрээтэй томоохон бодлого боловсруулж хэрэгжүүлэх

Зөвлөмж:

- Сургалтын ба эрдэм шинжилгээний өндөр хүчин чадалтай тоног төхөөрөмж бүхий орчин үеийн лабораторитой болох

4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн хөгжүүлэлтэд ач холбогдолтой гэж үзэхүйц гадаад харилцааны орчин бүрдүүлэх зорилгоор 8 орны 16 их, дээд сургууль, мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах, гэрээ ба санамж бичиг байгуулжээ. Эдгээр гэрээ хэлцлийн дагуу багш нарыг гадаадад мэргэжил дээшлүүлэх, зэрэг цол хамгаалуулах ба оюутан солилцох хөтөлбөр хэрэгжүүлж байна.
- ОХУ, БНХАУ, БНСУ, Японы РАСРС /8 оюутан/ компани зэрэг сургуулиудтай хөтөлбөр хэрэгжүүлэх урт богино хугацааны гэрээт үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулдаг.
- Төгсөгчидтэй тогтоосон байнгын үр ашигтай холбооны хүрээнд авсан судалгаанд анализ хийж сургалтын агуулга, хөтөлбөрийн хэрэгжилтэд жил бүр хөгжүүлэлт хийж байгаа талаар ӨҮТ-нд бичсэн нотлох баримтуудыг Шалгуур 4-ийн 7 хавтас материалд харуулжээ.
- Хөтөлбөрийн нээлттэй байдлыг хангаж талуудын оролцоог хангахын тулд www.monos.edu.mn сайтад хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, ахиц, оролцогч талуудын санал шүүмжийг судлах тэдгээрийн мөрөөр хөтөлбөрийн агуулга шинэчлэлийг сүүлийн 5 жилийн хугацаанд 1600 орчим хүсэлт, 200 гаруй өргөдөл, санал, хүсэлт хүлээн авч холбогдох шийдэл гаргаж хэрэгжүүлжээ.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Харьцангуй залуу хөгжлийн түүх богинохон ч ЭЗШУИС-ийн хөтөлбөрөө хэрэгжүүлэх олон талт хамтын ажиллагааны цар хүрээг үнэлэж болохоор байна

Анхаарах асуудал:

- Гадаадын өндөр хөгжсөн, дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн алдартай их сургуулиудтай хамтран ажиллах

Зөвлөмж:

- Төгсөгчид нэг бүртэйгээ тасралтгүй холбоо тогтоож тэдэнтэй байнгын хамтран ажиллагч байх тогтолцоог бүрдүүлэх

4.3 Санхүүжилт

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг,

олон эх үүсвэртэй байна.

Илрэл нотолгоо:

- Тус сургуулийн санхүүжилт үндсэн 3-н эх сурвалжтай.
 - o Үүнд: Суралцагчдын сургалтын төлбөр, Үндсэн үйл ажиллагааны орлого ба Монос группын хандив тусламж.
- ӨҮТ-нд тэмдэглэснээр 2014-2015 оны хичээлийн жилд 1,461,199,8 байсан бол 2018-2019 оны хичээлийн жилд 3,182,390,8 төгрөг болж өссөн бөгөөд сургалтын төлбөрийн орлого 95-97 хувийг эзэлж байна.
- Сүүлийн 5 жилийн хугацаанд урсгал зардалд 230,8 - 333,4 сая төгрөг зарцуулсан, өсөлтийн хувь 19,6.
- ТАХ –д 2018-2019 оны хичээлийн жилд буцалтгүй тусламжид 98, оюутны хөгжлийн зээлд 98 оюутан хамрагдаж байгаа нь эм зүйн салбарт суралцагсдын 16,4 хувийг эзэлж байна.
- Монос группээс тус сургуульд үзүүлж буй тусламж эм зүйн хөтөлбөрийн хэрэгжилтэд жинтэй нөлөө үзүүлж байгаа ажээ. Зөвхөн оюутан суралцагчдад олгосон тэтгэлэгт 37 оюутан 31,5 сая, хөнгөлөлтөд 30 оюутан хамрагдаж 4,5 сая, сүүлийн 5 жилд нийт 40 сая төгрөг зарцуулсан байна.
- Сургалтын кабинет, лаборатори, интернэт төв шинээр байгуулахад Монос группын салбаруудаас 48,1 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийж дэмжлэг үзүүлжээ.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- ЭЗШУИС-ийн онцлог нь Монос группын удирдах зөвлөлөөр жил бүр батлагдаж, тайлагнагддаг “Жилийн төсөв”-тэй байгууллага бөгөөд сургууль биеэ даасан санхүүгийн удирдлага менежментийн бодлогыг сургуулийн удирдах зөвлөлөөр хэлэлцэн баталгааждаг онцлог нь бусад хувийн хэвшлийн сургуулиудад туршлага болохоор ажээ.

Анхаарах асуудал:

- Монос группийн дэмжлэгийн хариуг жил бүр тайлагнаж хөрөнгө оруулалтын үнэ цэнийг нь мэдрүүлэх тодорхой үр дүнд хүрэх

Зөвлөмж:

- Эрдэм шинжилгээний ба сургалтын лабораторийг хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлэх санхүүжилтийг тасралтгүй өсгөх, үр дүнтэй хэрэгжүүлэх

4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

Илрэл нотолгоо:

- Тус сургууль Эм зүйч бэлтгэх бакалаврын хөтөлбөрөө сурталчлах маркетингийн үйл ажиллагааг элсэлтийн цар хүрээг өргөжүүлэх төдий бус харин хөдөлмөрийн зах

зээлийн судалгаа хэрэгцээтэй холбон үзэж үйл ажиллагаа явуулдаг юм байна гэж дүгнэж байна

- Оюутан бүрт төгсөөд гарч ажиллах ажлын байр олох, тандан судлах үйл ажиллагааг Монгол улсын хэмжээнд мөрдөгдөж байгаа эм зүйн байгууллагуудын улсын стандартын үзүүлэлттэй холбон авч үздэг
- Оюутнуудаас авсан олон зуун асуумж, судалгааны үр дүнгээр тэдний хэрэгцээнд нийцдэг үйл ажиллагаа болох нь нотлох баримтаар баталгаажсан байна
- Хөтөлбөрөө нийслэлийн 7 дүүрэг орон нутгийн ЕБС-иудад чиглүүлж хийсэн сурталчилгааны ажилд сүүлийн 5 жилд 30000 гаруй сурагчид хамрагдсан байна

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- “Хөдөлмөрийн зах зээл-Хөтөлбөрийн маркетинг” гэх агуулгатай маркетинг нь өвөрмөц бөгөөд тус хөтөлбөрөөр суралцагчдын эрэлт хэрэгцээнд нийцдэг

Анхаарах асуудал:

- Гадаадаас оюутан элсүүлэн суралцуулах асуудалд анхаарал тавих

Зөвлөмж:

- Гадаадаас оюутан элсүүлэн суралцуулах бэлтгэл хангах
- Хөтөлбөрийн агуулгыг гадаадын хамтын ажиллагаатай сургуулиудынхтай ижил түвшинд хүргэж хөгжүүлэлт хийх

4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн нээлттэй ил тод байдлыг хангах чиглэлээр хийж буй ажлыг
 - 1-рт, Үйл ажиллагаагаа бусдад ил тод сурталчлах,
 - 2-рт Нийгмийн дотрох ЭЗШУИС-ийн итгэл үнэмшлийг бэхжүүлэх арга зам хэмээн ач холбогдол өгч ажилладаг.
- Сургуулийн бүтэц үйл ажиллагааны нэгжээс эхлээд захиргаа хүртэл бүх шатны байгууллагыг хамруулан олон хэлбэрээр энэ чиглэлийн үйл ажиллагаа зохион байгуулдаг.
- Цахим мэдээллийг олон суваг, мэргэжлийн сэтгүүл, Үүлэн тооцоолуур зэрэг 10 шахам хэлбэрээр явуулдаг юм байна. Дамжуулсан мэдээллийн хэмжээ 870 GB, хандалтын тоо өндөр 5 жилд 33636766
- Монголын эм зүй, эм судлал 17-н дугаар гаргасан бөгөөд www.mongol.med.mn цахим сэтгүүлийн сайтад байрлуулсан,
- Eastren–Westren Pharmacology and Pharmacy сэтгүүл гаргаж эхэлсэн төдийгүй номхон далайн баруун бүсийн анагаахын сэтгүүлийг индексжүүлэх байгууллагын албан ёсны <http://wprim.whocc.org.cn/wss> сайтад байршуулсан байна

- Тус сургуулийн динамик вэб сайт www.monos.edu.mn –д сүүлийн 3 жилд 3,3 сая төгрөгийн шинэчлэл хийж одоо 300GB бөгөөд бүх оюутанд хүртээлтэй ашиглах болсон байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Элсэн суралцагчдын тоо жилээс жилд өсч байгаа
- Төгсөгчдийн мэргэжлээрээ ажиллаж байгаа хувь өндөр

Зөвлөмж:

- Сурталчилгаа маркетингийн үйл ажиллагаагаа гадаадын улс оронд гаргах

4-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

5.1. Суралцагч сонгох, элсүүлэх

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- БСШУЯ-наас баталсан оюутан элсүүлэх журмын дагуу элсэлтийн үйл ажиллагааг явуулдаг. ЭЗШУИС нь эм зүйн бакалаврын ангид элсүүлэх оюутны тоог гаргаж, сонгон шалгаруулах, элсүүлэх ажлыг сургуулийн оюутан элсүүлэх журмаар (Веб сайт www.monos.edu.mn) зохицуулдаг. Захирлын тушаалаар элсэлтийн комисс томилж, энэ комисс элсэлтийн үйл ажиллагааг зохицуулдаг ба ЭЗШУИС-д оюутан элсүүлэхэд БСШУЯ-ны сайдын 2013 оны А/79, 2016 оны А/87 тушаалаар батлагдсан Оюутан элсүүлэх журам, 2020-2021 оны хичээлийн жилд ЭЗШУИС-ийн захирлын 2020 оны 35 тоот тушаалаар батлагдсан оюутан элсүүлэх журмыг мөрдөж байна.
- Элсэлтийн журамд оюутан элсүүлэх шалгаруулалт, шаардлага ЭЕШ босго оноо 410 дээш, элсүүлэх хичээлийн төрөл, бүртгэх зарчим, сургалтын төлбөрийн хөнгөлөлт урамшууллыг тусгасан байна.
- Элсэгчдийн ЭЕШ-ийн дундаж оноо, чансаа, хүсэлт гаргасан болон элссэн суралцагчдын харьцаа
- Элсэхийг хүсэгчид ЭЕШ-ын хичээл тус бүрд 400-аас дээш оноотой, ЭЗШУИС-д 2015- 2020 онд 889 оюутан элсэн суралцсан. Элсэлтийн дундаж оноо 513,6 байна. Эм зүйн бакалаврын хөтөлбөрөөр 2015 онд 115, 2016 онд 204, 2017 онд 222, 2018 онд 263, 2019 онд 85 оюутан элсэн орсон байна.
- ЭЗШУИС-д 2015-2020 онд элсэн суралцсан элсэгчдийн тооноос харахад 2016-2017 онд элссэн оюутны тоо өмнөх оноос 77,4%, 2018, 2019 онуудад 8,8%-18,5%-иар өссөн бол 2019- 2020 оны хичээлийн жилд 67,6%-иар буурчээ. Энэ

үзүүлэлтээс элссэн оюутны тоо цөөрсөн нь ЕБС төгсөгчдийн тоо буурсантай холбоотой байна.

- ЭЗШУИС-д шинээр элсэн орж байгаа оюутнуудад чиглүүлэх сургалтад хамруулдаг бөгөөд Оюутны мөрдөх журам, Эм зүйчийн алтан дүрэм танилцуулж, оюутны мэдвэл зохих бүхий л асуудлыг хамарсан 87 хуудастай “Оюутны хөтөч” гарын авлага, материалаар хангадаг.
- Хичээлийн жилийн эхэнд шинээр элсэн суралцагсдыг захирлын тушаалаар ангид хуваарилан, 2 хоногийн чиглүүлэх сургалтыг Оюутны албанаас зохион байгуулдаг. Энэ үеэр сургуулийн хичээлийн байр, номын сан, лаборатори зэрэгтэй танилцуулдаг байна. Курс бүрийн төлөөлөл оролцсон суралцагч оюутнуудтай уулзаж ярилцахад тэдний сэтгэл ханамж 100% байлаа.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Шинээр элсэгчдээс оюутны зөвлөлд нэр дэвшүүлэх ажиллагааг 3 үе шаттайгаар явуулж, сонгож авдаг. Оюутны зөвлөлийн ажлыг Оюутны алба, сургуулийн удирдлагаас сайн дэмждэг, дэмжлэг үзүүлдэг.
- Оюутны хөдөлмөрийн бирж ажиллуулж, Монос группийн 15 охин компанид суралцагсдын хөдөлмөрийг дэмжигч байгууллагаар хамтран ажиллаж, оюутнуудыг урт болон богино хугацаагаар дадлагажуулан ажиллуулдаг. Дадлагажуулалт сайн хийгддэг болохыг ажил олгогч болон төгсөгчид ярьж байлаа.
- Оюутны сайн дурын 16 клуб идэвхитэй, албан ёсоор ажилладаг, Оюутны алба, сургуулийн удирдлага үйл ажиллагааг нь сайн дэмждэг. Санхүүжилт сайн хийдэг байна.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн агуулгыг уян хатан болгох, эмчилгээний гоо сайхны бараа, бүтээгдэхүүний талаар мэдлэг олгодог болгох

Зөвлөмж:

- Эмнэлгийн хэрэгсэл, оношлуур, эмийн сангийн барааны өрөлт, мерчиндайзинг хийх анхан шатны мэдэгдэхүүн олгох талаар хөтөлбөртөө тусгах,
- Клиник эм зүйн хичээлийн хөтөлбөр, цагийг анхаарч, нэмэгдүүлэх боломжийг судлах,
- Эмийн хими, эмийн технологи хичээлийн суурийг сайн тавьж өгөх, чанаржуулах, оюутнуудын сонирхлыг төрүүлэхүйц байдлаар хөтөлбөрт шинэчлэлт оруулах,
- Шинэ оюутнуудад ЕБС-ийн арга барилаас ИС-ийн сурах арга зүйн хэв маягт шилжих арга барилыг зааж зөвлөх, эрдэм шинжилгээ, хүмүүжлийн олон талт ажилд зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, татан оролцуулахад анхаарах,

5.2. Зөвлөн туслах үйлчилгээ

Суралцагчид суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- Зөвлөх, хөгжүүлэх үйлчилгээний төлөвлөгөө, график, үр дүн

- Оюутнуудад зөвлөх үйл ажиллагааг хүмүүжил, сургалтын үйл ажиллагаатай зэрэгцүүлэн тусгай төлөвлөгөөний дагуу тасралтгүй зохион байгуулдаг байна.
- 2015-2020 онд оюутанд зөвлөх, тэднийг хөгжүүлэх үйл ажиллагааг сургалтын, урлаг соёл, хүмүүжлийн, спортын арга хэмжээ зэрэг үндсэн чиглэлийг баримтлан, төлөвлөгөөний дагуу зохион байгуулсан байна. Анги бүрт зөвлөх багш томилон өгч, зөвлөх багш ангитайгаа 14 хоног бүр уулзаж, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлдэг байна. Ялангуяа шинээр элссэн оюутнууддаа түлхүү анхаардаг нь зохион байгуулсан ажлын тайлангаас харагдаж байна.
- 2015- 2020 онд ЭЗШУИС-ийн оюутны алба нь оюутан элсэн орохоос төгсөх хүртэлх нийгмийн асуудлыг шийдэх үйл ажиллагааг хариуцан ажилладаг. Оюутнуудын сурч боловсрох нөхцөлийг сайжруулах, оюутанд үйлчлэх үйлчилгээнд оюутны дотуур байр, оюутнуудад эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлдэг Синдүра- Мед, Намуун эмнэлэг, номын сан, спорт заал зэргийн үйл ажиллагаа ордог. Орон нутгаас суралцаж байгаа оюутнууд Оюутны байранд амьдарч, сурах боломжоор хангагддаг байна. Оюутны дотуур байрны хангамж харьцангуй сайн /боломжийн/, сурч боловсрох нөхцөлөөр хангаж өгсөн байдгийг оюутнууд ярьж байлаа.
- Зөвлөн туслах үйлчилгээний талаар оюутны сэтгэл ханамжийн судалгаа хийхэд 70% сайн, сэтгэл ханамжтай байжээ.
- 2018 оноос цахим сургалт болох Cloud university программ дээр бүх багш, оюутнууд ажиллаж эхэлжээ. Цахим лекцийн 34 төрлийн 1294 цагийн фондтой болж, оюутнуудад ашиглуулж байна.
- Зөвлөн туслах үйлчилгээний төлөвлөгөөний биелэлт, ажлын гүйцэтгэл, чанарын ахицад ЭЗШУИС-ийн чанарын дотоод баталгаажилтын алба хяналт тавьж, үнэлгээ дүгнэлт өгч, сайжруулах арга хэмжээг авч ажилладаг байна. Чанарын дотоод баталгаажилтын албанаас зөвлөн туслах үйлчилгээний үр дүн, чанарыг сайжруулах зорилгоор суралцагсдаас жил бүр судалгаа авч, үр дүнг удирдлагын багаар хэлэлцэн, сайжруулах чиглэлээр холбогдох ажилтнуудад үүрэг даалгавар өгч, баримтжуулсан байна.
- Суралцагчдад үзүүлэх зөвлөн туслах үйлчилгээг сайжруулах зорилгоор “Захиргаа-Оюутан”, “Захиргаа-Багш-Оюутан” гэсэн зангиагүй уулзалт хэлэлцүүлгийг жилд 1 удаа зохион байгуулж, санал бодлыг нээлттэй сонсож, холбогдох арга хэмжээнүүдийг авсан байна.

- Бие хүний төлөвшил, харилцаа, ёс зүйн /зан үйл, зөрчил шийдвэрлэх, эрүүл аж төрөх г.м/ чиглэлүүдээр сургалт явуулж, ур чадвар олгодог байдал

- Суралцагсдын хөгжил, төлөвшилд чиглэсэн үйл ажиллагааны хүрээнд мэргэжлийн чиг баримжаа олгох хөтөлбөрийн дагуу цуврал лекц, семинар, танилцуулах үйл ажиллагаа нь төлөвлөсөн графикайн дагуу явагддаг нь

төлөвлөгөө, тайлангаас харагдаж байна. Эдгээр үйл ажиллагаанд дотоодын болон зочин багш, оюутны зөвлөл, залуу илтгэгч клуб хамтран оролцдог байна.

- Суралцагчдын төлөвшил, соёл олон нийтийг хамарсан олон төрлийн сонирхолтой ажиллагаа, оюутны урлаг, спортын их наадам, улсын хэмжээний уралдаан, тэмцээн /энэ жилийн оюутны сагсан бөмбөгийн аварга шалгаруулах тэмцээнд эрэгтэй баг мөнгөн медаль авсан/, явган аялал, сайн үйлсийн аян, АХА тэмцээн, танин мэдэхүйн “Алтан хонх” тэмцээн, оюутны эрдэм шинжилгээний хурал зэрэг арга хэмжээг зохион байгуулж, баримтжуулсан байна.

- Суралцагчийн судалгаа, шинжилгээний үйл ажиллагааг дэмжин тусалсан байдал

- ЭЗШУИС-ийн оюутнууд эрдэм шинжилгээ, судалгааны орчин үеийн аргуудад суралцаж, ЭШС-ны ажлын сэдэв гаргаж, сэдэв сонгосон оюутныг тухайн чиглэлээр багш нар удирдан ажилладаг байна. Багш бүр өөрийн судалгааны чиглэлээр оюутны эрдэм шинжилгээний дугуйлан хичээллүүлж, эрдэм шинжилгээний ажлыг нь удирдаж байна.
- Тус сургуулийн Эм зүйн удирдлага технологийн тэнхимийн дэргэд “Journal club” ба “Залуу судлаач” клуб байгуулан, багшийн удирдлаган дор судалгаа шинжилгээний ажил хийж, 20 гаруй нэр төрлийн эм болон гоо сайхны бүтээгдэхүүн санаачлан хийж, дээжээр нь үзүүлэн гаргажээ.
- ЭЗШУИС нь жил бүрийн 4 сард оюутны дунд эрдэм шинжилгээний хурлыг хамтран ажилладаг гадаадын 4 их сургуулийн (Герман Дюссельдорф ИС, Австри улсын Грац ИС, Солонгос ОУИС, ОХУ-ын Буриад ИС) багш эрдэмтдийг урьж, зохион байгуулдаг болжээ. Олон улсын оюутны эрдэм шинжилгээний хурлыг англи хэл дээр зохион байгуулсан байна.
- Хятад улсад зохион байгуулагдсан Оюутны олон улсын IX чуулганд оюутнуудаа оролцуулж, 2 оюутан илтгэлээ амжилттай хэлэлцүүлсэн байна.
- Сургуулийн удирдлага нь оюутны байгууллагаас зохион байгуулдаг олон нийтийн арга хэмжээ, үйл ажиллагаанд санхүүгийн дэмжлэг үзүүлдэг байна. Ямар үйл ажиллагаанд хэдэн төгрөг зарцуулснаа тооцсон санхүүгийн тайлангаа гаргасан байна. Санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулсан байгаа нь тайлангаас харагдаж байна.
- ЭЗШУИС-ийн оюутанд үзүүлэх үндсэн үйлчилгээ нь сургуулийн чиг үүрэг, бүрэн эрх, санхүүжилт, ажиллах нөхцөл, оюутан дадлага хийх, хөдөлмөр эрхлэхэд туслах, урамшуулах, дэмжлэг үзүүлэх зэрэг зохион байгуулалтын хүрээнд үйлчилж байна. Сургуулийн болон Монос группын зүгээс оюутны байгууллагад үзүүлэх дэмжлэг сайн, зохион байгуулж байгаа үйл ажиллагааг бүх талаар дэмждэг болохыг нотлох баримтаар, оюутнуудын төлөөлөлтэй ярилцах аргаар дүгнэлээ.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Монос группийн салбар компаниуд ЭЗШУИС-ийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлдэг.

Анхаарах асуудал:

- Эрдэм шинжилгээ, судалгааны ажилд оролцох оюутны тоог нэмэгдүүлэх, идэвхийг сайжруулах

Зөвлөмж:

- Оюутны эрдэм шинжилгээ судалгааг хөхүүлэн дэмжиж, оролцогсдын тоог нэмэгдүүлэх,
- Оюутнуудын дотуур байрны хангамжийг сайжруулахад байнга анхаарч өргөжүүлэх
- Сургалтын хөтөлбөрийн агуулгын хүрээнд бие даалтаар судлах хичээлийн сэдвүүдийг тодорхойлж, оюутны зайлшгүй унших, ашиглах мэдээллийн эх сурвалжийн жагсаалт, эзэмших ур чадвар, гүйцэтгэх үйлдэл, гүйцэтгэлийг тооцох хэлбэр хугацааг тодорхойлох,

5.3 Суралцагчийн олон нийтийн оролцоо, урамшууллын тогтолцоо

Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- ЭЗШУИС-ийн Оюутны сайн дурын ажлыг үнэлэх журамтай, мөрдөн ажилладаг. Багш, оюутны санаачлагаар байгуулагдсан 16 оюутны сайн дурын клубууд үйл ажиллагаагаа нээлттэй явуулж байна. Клуб бүр үйл ажиллагааны чиглэлээр төлөвлөгөөтэй ажиллаж байна. Сайн дурын клубуудын үйл ажиллагаа нь оюутны хүсэл сонирхолд тулгуурласан, шинэ санаа, санаачлагыг дэмжсэн байдаг байна. 2015-2020 оны хугацаанд давхардсан тоогоор клубын үйл ажиллагааг идэвхижүүлэхэд зориулж, 250 гаруй сургалт, 25 сая төгрөг зарцуулсан байна.
- Сургуулийн оюутны албаны дэргэдэх “Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв” ажиллаж, үйл ажиллагаандаа “Оюутан суралцагсдыг цагийн ажилд зуучлах журам”-ыг мөрдөн ажилладаг байна. Монос группийн салбар охин компанийн Хүний нөөцийн газруудтай хамтран оюутнуудын хөдөлмөрийг дэмжих ажлын хүрээнд хичээлийн бус цагаар дадлагажуулан ажиллуулдаг уламжлал тогтсон нь оюутны орлогыг нэмэгдүүлэх, хөдөлмөрийн харилцааны төлөвшил, мэргэжлээ зөв тодорхойлох, чөлөөт цагийн сонголтыг өргөтгөсөн байна. Суралцагсдын дунд 9 төрлийн тэмцээн уралдааныг жил бүр зохион байгуулж, түүний үр дүнг гарган, баримтжуулсан байна.
- 2015- 2020 оны хичээлийн жилд шинээр элссэн >650 оноо авсан 21 оюутанд төлбөрийн хөнгөлөлт үзүүлсэн байна. Боловсролын зээлийн сан, Оюутны хөгжлийн зээлд оюутнуудаа хамруулахаар ажиллаж байна. Мөн оюутны албанаас автобусны цахим карт захиалан авах, сунгуулах ажлыг зохион байгуулж, тайлангийн хугацаанд давхардсан тоогоор 4035 оюутныг хамруулжээ.

- Урамшуулал, тэтгэлэг хөнгөлөлтөд хамрагдсан суралцагчдын тоо

- ЭЗШУИС-ийн оюутнууд 2015-2020 оны хичээлийн жилд тэтгэлэг, урамшуулалд хамрагдсан судалгаанаас харахад нийт 59 оюутан Монос Улаанбаатар, Монос Фарм Трейд, Монос Фарм, Монос групп, Л. Эрдэнэчимэг захирлын ЭМЯ-ны сайдын

нэрэмжит, Оюу толгой ХХК-ийн, ЭЗШУИС-ийн захирлын зэрэг 9 тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдсан байна.

- Оюутны зөвлөлд ажилладаг суралцагсдын сургалтын төлбөрийг жил бүр 10% хөнгөлж, үйл ажиллагааг дэмждэг нь оюутнуудыг Зөвлөлд ажиллахад нөлөөлдөг байна.
- Суралцагсдын амжилт, идэвхи чармайлтыг үнэлэн, 2015- 2020 онд МЗХ, МОХ, МҮОХ зэрэг оюутан, залуучуудын байгууллага, Монос группийн, ЭЗШУИС-ийн зэрэг шагналуудаар шилдэг оюутнуудаа шагнасан байна.
- Урамшуулал, тэтгэлэг, хөнгөлөлтөд зарцуулсан төсвийн тайлангууд байлаа.
- Манлайлагч оюутныг бэлтгэх зорилгоор 2-р курсээс сонгоны анги нээж ажиллуулсан байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Оюутнууд оюутны зөвлөлд орж ажиллах сонирхолтой, өрсөлдөж, шалгарсан нь ордог юм байна.

Анхаарах асуудал:

- Бусад эм зүйн сургуулиудтай Оюутнуудын эрдэм шинжилгээ судалгааны хурал, уулзалт зөвлөгөөн, туршлага солилцох ажлыг хамтран зохион байгуулах,

Зөвлөмж:

- Оюутнуудын гадаад хэлний мэдлэгийг дээшлүүлэх, суралцах боломжоор нь хангах,
- Ажил олгогч нартай гэрээ байгуулан, оюутнуудын тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдагсдын тоог нэмэгдүүлэх
- Гадаадын ижил төстэй их сургуулиудтай оюутан солилцох, туршлага судлах, эрдэм шинжилгээний хурал, уулзалт, дадлагажуулах зэрэг хамтын ажиллагааг улам бүр өргөжүүлэх,

5.4. Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

Илрэл нотолгоо:

- Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэсэн байдал

- Оюутны шилжилт хөдөлгөөнийг ЭЗШУИС-ийн захирлын тушаалаар батлагдсан сургалтын үйл ажиллагааг зохицуулах журмын дагуу шийдвэрлэдэг.
- Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх зэргээр холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нийцүүлэн шийдвэрлэж хэвшсэн байна.

- Шилжилт хөдөлгөөний судалгаа, дүгнэлт

- ЭЗШУИС-ийн оюутнуудын 2015- 2020 оны хичээлийн жилийн шилжилт хөдөлгөөний судалгаанаас харахад нийт 518 оюутан шилжилт хөдөлгөөн хийжээ.

- Судалгаанаас харахад гадаад, дотоодын сургуулиас шилжин ирсэн оюутны тоо 126, өөр сургуульд шилжсэн оюутны тоо 111, жилийн чөлөөнөөс ирсэн 153 байна. Хувиар тооцвол, шилжиж ирсэн нь 24%, өөр сургууль руу шилжсэн нь 21% байна.
 - Шилжилт, хөдөлгөөний судалгаа хийж, үнэлэлт, дүгнэлттэй ажилладаг юм байна. Шилжин явсан суралцагсдаас шалтгааныг тодруулах судалгаа авч ажилласан байна.
- Шилжилт хөдөлгөөнийг зохицуулж буй дүрэм, журам, гэрээний хэрэгжилт, суралцагчийн эрх ашгийг дээдэлсэн байдал**

- Сургалтын алба нь шилжих, шилжин ирэх хүсэлт гаргасан оюутны асуудлыг захиргааны зөвлөлийн хурлаар шийдвэрлүүлдэг байна.
- Захирлын тушаал гарсан тохиолдолд шилжиж ирсэн оюутны хичээлийн зөрүүг ЭЗШУИС-ийн оюутны алба гаргадаг ба хичээлийн багц цагийг өөрийн сургуулийн баримталдаг багц цагаар тооцдог.
- Шилжин ирсэн оюутнуудыг зөрүүтэй хичээлээ бие даан нөхөж суралцах боломжоор бүрэн хангадаг байна.

Зөвлөмж:

- Батлагдсан дүрэм, журмын дагуу үйл ажиллагааг үргэлжлүүлэх боломжтой гэж үзлээ.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Анхаарах асуудал:

- Шилжилт хөдөлгөөн, жилийн чөлөө авалт их байна. Ялангуяа сургалтын төлбөрөө төлж чадахгүй байгаа суралцах сонирхолтой оюутныг дэмжихэд анхаарах, боломжийг судлах,

Зөвлөмж:

1. Тэтгэлэгт хөтөлбөрийг нэмэгдүүлэх арга замыг судлан, хэрэгжүүлэх

5.5. Төгсөлтийн баримт бичиг

Төгсөлтийн баримт бичиг нь оюутны мэргэшил, хувь хүний гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг тусгасан байна.

Илрэл нотолгоо:

- ЭЗШУИС нь Боловсролын тухай хууль, БСШУЯ-ны “Дээд боловсролын диплом олгох тухай” тушаалыг үндэслэн, өөрийн сургуулийн төгсөлтийн баримт бичгийг олгох журам баталж, мөрдөн ажиллаж байна. Энэ журамд оюутны төгсөлтийн шалгалт, төгсөлтийн бичиг баримттай холбоотой үйл явцын зохицуулалтыг тодорхой заасан байна.
- Баклаврын зэргийн болзол хангасан төгсөгчид шалгалтын комиссын шийдвэрийг үндэслэн ЭЗШУИС-ийн захирлын тушаалаар төгсгөж байна.
- Эм зүйчийн диплом нь англи, монгол хэл дээр бичигдсэн, хавсралт бүхий 6 хуудас, бүртгэлийн дугаартай, гарын үсэг, тамгаар баталгаажсан байна. 2015- 2019 онд нийт 603 төгсөгч Эм зүйч мэргэжлийн “Диплом” авсан байна.
- Төгсөлтийн комисс нь төгсөлтийн баримт бичиг, баримтын эх хувийг архивт бүрдүүлж өгөхөөс гадна цахимаар шалгах боломжтой болгосон байна.
- Төгсөлтийн баримт бичигтэй холбоотой зөрчил, санал гомдол гараагүй байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

5-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

6.1. Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлого

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

Илрэл нотолгоо:

- Эм зүй хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чадварлаг багш шалгаруулан авах хүний нөөцийн бодлого баримтлан ажиллаж байна.
- ЭЗШУИС-ийн багш албан тушаалын зэрэглэлээс үл хамааран нэг хичээлийн жилд 30 багц цагийн нормтой байна

Докторын зэрэгтэй багшийн сүүлийн 5жилийн судалгаа:

5	Хичээлийн жил	Нийт багш	Доктор	Эзлэх:%
1	2015-2016	37	16	43.2%
2	2016-2017	38	16	42.1%
3	2017-2018	39	16	41.0%
4	2018-2019	44	18	41.0%
5	2019-2020	53	19	35.8%

Багш суралцагчдын сүүлийн 5 жилийн тооны харьцаа:

	Хичээлийн жил	Нийт багш	Оюутан	Харьцаа
1	2015-2016	37	587	1:16
2	2016-2017	38	673	1:18
3	2017-2018	39	768	1:20
4	2018-2019	44	956	1:22
5	2019-2020	53	963	1:18

- Дээд боловсролын тухай хууль, ЭЗШУИС-ийн багшийн хөдөлмөр, түүнийг тооцож дүгнэх журмын дагуу улирал тутам ур чадварын нэмэгдэл цалин, сургуулийн “шилдгүүд шалгаруулах журам”-ыг баримтлан жилд нэг удаа шилдэг багшийг урамшуулан шагнадаг байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэх гол үндэс болсон багшлах хүний нөөц бүрдүүлэх шалгаруулалтын бодлоготой
- Багш нарыг хөгжүүлэх эдийн засгийн хөшүүрэг хэрэглэдэг

Анхаарах асуудал:

- Багш нарын мэргэжлийн дадлагыг сайжруулах

Зөвлөмж:

- Багш нарыг хөгжүүлэх зорилгоор явуулж байгаа эдийн засгийн хөшүүргийг тэдний хариуцлагатай нягт холбох нь зүйтэй

6.2. Багшийн хөгжил

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжилийн хөтөлбөртэй байна.

Илрэл нотолгоо:

- Багш бүр өөрийн хөгжлийн 5 жилийн төлөвлөгөөг дараах чиглэлээр гаргадаг: сурган заах арга, мэдлэг чадвар, багшийн мэргэжил дээшлүүлэлт, судалгаа, эрдэм шинжилгээ, бүтээл туурьвал гаргахыг чухалчилж байгаа
- Багш өөрийгөө хөгжүүлэхийг сургууль дэмждэг, өндөр хөгжилтэй улс оронд давхардсан тоогоор 46 багшийг, дотоодын сургалтанд 126 багшийг мэргэшүүлэх болон мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагдсан .
- Сүүлийн 5 жилийн хугацаанд 25 багш магистрантурт, 21 багш доктрантурт, 70 багш англи хэлний, 25 багш сурган-заах аргын сургалтанд тус тус хамрагдсан байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлого зүйл/Туршлага:

- Эм зүйч мэргэжлийн багш нар жил бүр 6 кредитийн сургалтанд заавал хамрагддаг болсон

Анхаарах асуудал:

- Нарийн мэргэжлийн хичээл хоорондын уялдаа холбоог сайжруулах зорилгоор сургалтыг цогц хэлбэрээр явуулах

Зөвлөмж:

- Хичээл хоорондын уялдааг сайжруулж оюутанд цогц мэдлэг чадвар эзэмшүүлэх

6.3. Эрдэм шинжилгээ, судалгаа

Багш, эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна

Илрэл нотолгоо:

- Монос группын санхүүжилтээр сүүлийн 5 жилд 74 төсөлт ажил, 6 инновацийн төсөл хэрэгжин, фармакопейн өгүүлэл 43, стандарт 12, патент 14-г батлуулсан байна.
- Улсын хэмжээний эрдэм шинжилгээний сэтгүүлүүдэд 106 өгүүлэл, ОУ хуралд 100 илтгэл, дотоодын хуралд 154 илтгэл хэлэлцүүлсний дээр 1 сэдэвт бүтээл 7, ном гарын авлага 64 гаргасан байна.
- Тус сургуулийн доктор багш нар 15 докторын, 70 магистрын ажлыг удирдаж хамгаалуулсан байна.
- Гадаадын нэр хүндтэй сэтгүүлүүдэд Томсон Ройтерст бүртгэлтэй импакт фактор бүхий ОУ-ын мэргэжлийн сэтгүүлүүдэд 15 хамтарсан бүтээл хэвлүүлсэн байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Багш бүрийг судалгааны ямар нэг ажилд хамруулж бүтээл /илтгэл, өгүүлэл, бусад/ гаргах шаардлага тавьж ажлын үндсэн үзүүлэлт болгосон

Анхаарах асуудал:

- Оюутанд багшийн нөлөөллийг дээшлүүлэх, бүх оюутнаа судалгааны ажилд жигд оролцох эрмэлзлэлтэй болгох талаар тодорхой ажил зохион байгуулах

Зөвлөмж:

- Шинжлэх ухаан технологийн сан зэрэг байгууллагын төсөлт эрдэм шинжилгээний ажилд багш оюутнуудын хүч нөөцийг дайчлан оролцуулах талаар анхаарч тодорхой бодлого хэрэгжүүлэх

6.4.Багшийн үнэлгээ

Багшийн: сургалт заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжилийн болон нийгмийн үйлчилгээний \зөвлөх үйлчилгээ\ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж үр дүнг тогтмол тооцдог байна.

Илрэл нотолгоо:

- Багшийг хөгжүүлэх, тэдний албан тушаалын зэргийг өсгөх, ажлын үр дүнгээр цалингийн урамшуулал олгох, эрдмийн зэрэглэлд болон шагналд нэр дэвшүүлэхэд багшийн өөрийн ба хөндлөнгийн үнэлгээний тайлан,багшийн ажлын хавтас, хэрэгжүүлсэн ажлын тайлан зэргээр 9 багшийг дэд профессорын, 2 багшийг профессорын зэрэглэлд, 5 багшийг ахлах багшийн зэрэглэлд дэвшүүлэн ажиллуулсан байна.
- Багш нарын ажлыг үнэлэх үзүүлэлт нь багшийн хөгжилд хандсан үзүүлэлттэй
- Багшийн хөгжлийг хангах зорилгоор эдийн засгийн хөшүүрэгт жил бүр хөрөнгө зарцуулдаг болсон

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан.

Онцлог зүйл/Туршлага:

- Багш бүрийн үйл ажиллагаа, ажлын үр дүнг зөв үнэлэх нарийн тооцоотой болсон байна

Зөвлөмж:

- Багш нарын манлайллыг оюутанд үзүүлсэн үлгэрлэлээр хэмжих тогтолцоотой болох

6-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан.

Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

7.1. Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалт

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн үечилсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын механизмтай байна.

Илрэл нотолгоо:

- ЭЗШУИС-ийн чанарын дотоод баталгаажуулалтын журмыг захирлын 2013 оны 84 тоот тушаалаар, 2019 оны 184Б тоот тушаалаар Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажилтын багийг 9 хүний бүрэлдэхүүнтэйгээр томилон, ажиллуулж байна.
- Дотоод хяналт үнэлгээний арга зүйчийг орон тоогоор ажиллуулдаг юм байна. Энэ баг нь сургуулийн үйл ажиллагаанд чанарын баталгаажуулалт, хөтөлбөрийн түвшинд өөрийн үнэлгээг хийж, тайлагнах, шийдвэрлүүлэх зэргээр сургалтын чанарын баталгааг хангахад анхааран ажилладаг байна. Чанарын үнэлгээ, баталгаажилтад SWOT, TOWS шинжилгээ хийж, дүгнэсэн байна.
- ЭЗШУИС-ийн Чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх хөгжүүлэх, төлөвшүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлэхэд анхаарч, “ЭЗШУИС-ийн стратеги бодлого 2019- 2024”, сургуулийн ЧДБ-ын журам, сургалтын хөтөлбөрийн чанарыг үнэлэх журам, хичээлийн үнэлгээний удирдамж, шалгуур үзүүлэлт зэрэг нэгдсэн бодлогоор хөтөлбөрийг чанартай явуулах нөхцөлийг бүрдүүлсэн байна.
- Сургуулийн алсын хараа, эрхэм зорилго, стратегитай уялдуулан чанарын бодлого, зорилтоо тодорхойлсон байна. Олон улсын ISO 9001:2015 Чанарын менежментийн тогтолцоо стандартын хэрэгжилтийн хүрээнд Чанарын гарын авлага боловсруулан ажиллаж байна. Чанарын дотоод баталгаажуулалтын үйл ажиллагааны төлөвлөгөөг удирдлага зохион байгуулалт, үнэлгээ, судалгааны, судалгаа, шинжилгээний, хяналт шинжилгээ, судалгааны гэсэн 4 чиглэлээр жил, сараар гаргаж, сургуулийн захирал баталгаажуулсан байна.
- Дүрэм журмыг тогтмол хугацаанд шинэчлэн сайжруулж, хэрэгжилтэд хяналт тавьдаг.
- ЭЗШУИС нь хөтөлбөрийн гадаад, дотоод оролцогч болон сонирхогч талуудыг тодорхойлж, тэдний хэрэгцээ, хүлээлтийг хангагдаж байгаа эсэхийг тусгай үзүүлэлтүүдээр сэтгэл ханамжийн болон мөшгих судалгааны дүнгээр хянадаг. Хийгдсэн судалгаануудыг жил жилээр гаргасан байна.
- Эм зүйн хөтөлбөрийг сургалтын алба, тэнхим, багш нар хамтран тэнхимдээ баталгаажуулалт хийх, сургууль болон хөндлөнгийн оролцогч талуудын оролцоотой баталгаажуулалт хийх гэсэн 2 төрлийн удирдамжаар өөрийн үнэлгээ хийж, баримтжуулсан байна.
- Хөтөлбөрийн хороо нь Сургалтын хөтөлбөрийн чанарыг үнэлэхдээ сургалтын хөтөлбөрийн боловсруулалт, хэрэгжилт, хичээлийн хөтөлбөрийн хэрэгжилт гэсэн 3 хэлбэрээр үнэлсэн байна. Хөтөлбөрийн дэд хороо нь 2015-2020 оны хичээлийн жилд 33 удаа хөтөлбөр хэлэлцэж, ерөнхий хороо нь 3 удаа хуралдаж, хөтөлбөрийн агуулагад шинэчлэлт оруулсан байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Сургуулийн үйл ажиллагаанд ISO 9001:2015 Чанарын менежментийн тогтолцоо хэрэгжүүлэх ажлыг эхлүүлсэн байна. Чанарын гарын авлага боловсруулан баталсан байна.

- Чанарын бодлого, зорилтоо тодорхойлсон, үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллаж байна.
- Монос группийн дотоод аудит ордог.

Анхаарах асуудал:

- Чанарын зорилтуудаа тодорхой, хэмжигдэхүйц болгох,
- Эрсдлээ баг бүр нарийн тооцож, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах

Зөвлөмж:

- Чанарын Менежментийн Тогтолцоон дахь хөтөлбөрийн чанарын тасралтгүй сайжруулалтыг жил бүр хийж, PDCA циклийг эргүүлж хэвшүүлэх,
- Оюутан, багш, ажилтнууд, сонирхогч талуудаас гарсан санал, гомдлыг хянан шийдвэрлэх журамтай болж, бүртгэлжүүлэх, баримтжуулах

7.2. Хөтөлбөрийн үр дүн

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна.

Илрэл нотолгоо:

- ЭЗШУИС-ийг 2005 оноос хойш төгссөн эм зүйчдийн /1374/ 95% ажил эрхэлдэг. Эм зүйн хөтөлбөрийг 175-аас доошгүй кредит цуглуулсан, 2-оос доошгүй голч дүнтэй суралцагсад эм зүйч бакалаврын зэргийг олгодог нь судалгаанаас харагдаж байна.
- Сургуулийн оюутны алба, төгсөгчдийн холбоо хамтран ажил эрхлэлтийн судалгааг жил бүр гаргасан.
- ЭЗШУИС-ийн Эм зүйн мэргэжлээр төгсөгчид эмнэлгийн эм зүйн алба, эмийн сан, эмийн үйлдвэр, лаборатори, ЭХНБ зэрэг байгууллагуудад ажиллаж байна. Тухайлбал: 2015-2019 оны байдлаар 604 эм зүйч төгссөнөөс төгсөгчдийн ажил эрхлэлт 92%- 94,6%-тай, төгсөгчдийн 90,1% нь төгсөөд 1-3 сарын дотор ажилд орсон байна. Энэ 5 жилийн хугацаанд төгсөх ангийн оюутнуудын 40-70% нь сургуулиа төгсөхөөс өмнө ажлын байрны захиалга авч, ажилд орсон байна.
- Дотоод, гадаадын их, дээд сургуульд 51 хүн үргэлжлүүлэн суралцаж байна.
- 2015-2019 онд 412 ажил олгогч, 605 төгсөгч, 477 төгсөх ангийн оюутнууд, 25 мэргэжлийн зөвлөлийн гишүүдийг хамруулан хөтөлбөрийн үр дүнгийн судалгаа явуулсан.
- Төгсөгчдийн сэтгэл ханамжийн судалгааг 2015 оноос өмнө төгссөн төгсөгч 326 хүнийг хамруулан 2 удаа хийжээ. Судалгаанд оролцогсдын 51% нь ажлын байранд тавигдаж байгаа шалгуурт нийцсэн, 57,5% нь эзэмшсэн мэдлэг нийцсэн гэсэн үнэлгээг өгсөн.
- Ажил олгогчийн сэтгэл ханамжийн судалгааг 192 ажил олгогчоос авснаас 87% нь ажлын байранд тавигдах шаардлагад төгсөгчдийн мэдлэг чадвар нийцэж байна гэж үнэлжээ. Ажил олгогчдын төлөөлөл Монос Улаанбаатар, МЭИК, УГТЭ, УХТЭ, Азифарма, Цомбо зэрэг эмийн үйлдвэр, ЭХНБ, эмийн сангийн

эрхлэгч, гүйцэтгэх заирал, дарга нартай уулзалт хийж ярилцав. Ажил олгогчид сургалтын агуулгыг одоо мөрдөгдөж буй хууль, тогтоол шийдвэртэй холбож өгөх, эмийн сангийн бүртгэл, санхүүгийн тооцоо, үндсэн суурь хичээлийн хөтөлбөр ялангуяа эмийн химийн хичээл зэрэг асуудалд анхаарах, мэргэжлийн онцлогоо ухамсарлахад сургууль, багш нар анхаарч ажиллахыг зөвлөж байлаа.

- Төгсөгчдийн төлөөлөл Монос, МЭИК, Азифарм, Цомбо, Зэвсэгт Хүчний Клиникийн Төв Эмнэлэг, ХОН-ийн ЭХНБ, бусад эмнэлэг зэрэг улсын болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудад ажиллаж байна. Ажил олгогчид болон төгсөгчдийн зүгээс суралцагчдад мэдлэг, чадвар олгохын зэрэгцээ төгсөгчдийн төлөвшил, ёс зүйн асуудалд анхаарах нь чухал гэдгийг онцолж байна.
- Оюутны албанаас хийсэн ажил олгогч компаниудаас төгсөгчдийн карьер өсөлтийн судалгаа авсан дүнгээс харахад төгсөгчдийн 34% нь албан тушаал ахиж, салбар хариуцсан захирал, төлөөлөгч, эрхлэгч, албаны дарга, ахлах менежер зэрэг албан тушаалд ажиллаж байна. Төгсөгчдийн карьер өсөлтийг дэмжих зорилгоор 2 курсээс нь өндөр голч дүнтэй оюутныг сонгон авч, сонгоны анги нээх, нэрэмжит тэтгэлэгүүдэд хамруулах ажлыг зохион байгуулсан байна. Төгсөгчдөө чадавхижуулах зорилгоор урт, богино хугацааны давтан сургалт явуулах зөвшөөрөл авч, явуулж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Чанарын дотоод баталгаажуулалтын багаас сэтгэл ханамжийн судалгааг тогтмол авч, үнэлдэг. Сайжруулах, залруулах үйл ажиллагааг удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлж, шийдвэрлүүлдэг.
- Төгсөх курсын оюутнуудыг Монос группийн салбаруудад цалинтай ажил дадлага хийлгэдэг.

Анхаарах асуудал:

- Төгссөний дараа зөвлөх үйлчилгээ үзүүлдэг байх,

Зөвлөмж:

- Төгсөх ангийн оюутнуудыг мэргэжлийн тодорхой чиглэлээр мэргэшүүлэхэд анхаарах,
- Төгсөлтийн дараах сургалтыг үе шаттайгаар зохион байгуулах,
- Эм зүйчийн ёс зүй, харилцаа хандлагын хичээлийн агуулгыг боловсронгуй болгох, заах арга зүйг оновчтой тодорхойлох
- Ажлын байранд тавигдах шаардлагыг хангах оновчтой шийдлийн дагуу сургалтын агуулгыг боловсронгуй болгох

7.3. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх

Үндэсний болон олон улсын хэмжээнд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэн суралцагчдын цогц чадамжийг хүлээн зөвшөөрүүлж, олон улсын түвшинд суралцах боломжийг нэмэгдүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- “Эм зүйн” хөтөлбөрийн магадлан итгэмжлэлд 2015 онд орж, БМИҮЗ-ийн 2015 оны 03/15 тоот тогтоолоор Эм зүйн хөтөлбөр магадлан итгэмжлэгдсэн байна. 2015- 2020 онд эм зүйн хөтөлбөрт хөндлөнгийн үнэлгээ хийгдэж, 2015 онд ЭЗШУИС, А/128 тоот тушаалаар “Эм зүй” докторын сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл, “ENTETREPRENEUR-2015” Боловсролын Энтрепренер шилдэг цомын эзэн болжээ. Эм зүйн мэргэжлийн сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээг 2019 онд сунгуулжээ.
- Төгсөгчдийн эм барих мэргэжлийн эрхийн шалгалтын үнэлгээний судалгаанаас харахад сүүлийн 5 жилийн дунджаар 99,1% амжилттай үнэлэгдсэн байна. Энэ нь сургалтын хөтөлбөрийн чанар, үр дүнг харуулах нэг гол үзүүлэлт мөн гэж үздэг.
- БНХАУ, Наньжин хотын ЭЗИС болон ОХУ-ын Эрхүү хотын АУИС-ийн Эм зүйн тэнхим, Буриадын Эм зүйн сургуультай багш, оюутан солилцох арга хэмжээг амжилттай зохион байгуулсан байна. 2015 оноос хойш 7 улсын 13 их сургуультай сургалт, судалгааны албан ёсны хамтын ажиллагаатай ажиллаж байна. БНХАУ-ын Наньжин ЭЗИС-д 8 багш сургалтад, Япон Тохоку 3 багш судалгаанд, Хятад улсын ЭЗИС-д 4 багш сургалтад, ХБНГУ-д 2 багш туршлага судалсан, ОХУ-ын Эрхүү, Улаан Үүд хотод 13 оюутан, 2 багш богино хугацааны дадлага хийсэн байна.
- ЭЗШУИС-ийн “Эм зүйч” бакалаврын хөтөлбөрөөр төгсөгчид нь эмийн салбарт ажиллагсдын 45 %-ийг эзэлж байна. Ажил олгогчдоос төгсөгчдийн мэдлэг, чадварт өгсөн үнэлгээний дүнгээс харахад 2016 оноос 2019 онд 21%-иар өссөн байна.
- Эм зүйн бакалаврын сургалтын хөтөлбөрт МЭЗБН Эм холбоо ТББ, Эм Зүйн Шинжлэх Ухааны академи үнэлгээ хийсэн байна. ЭЗШУА-ийн 2018 онд, Эм холбооны 2019 онд өгсөн санал, дүгнэлтийг авч, төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлэн ажиллаж байгаа юм байна.
- Чанарын үнэлгээ, баталгаажилтын өөрийн үнэлгээний тайланд SWOT, TOWS анализ хийж, давуу сул тал, боломж, эрсдэлээ тооцсон байна.
- Яг одоогийн байдлаар тус сургуульд гадаад оюутан суралцаагүй байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Сургуулийнхаа хөгжлийн шат бүхэнд өөрийн үнэлгээ хийж дараагийн зорилтоо дэвшүүлэхдээ улсын болоод олон улсын хэмжээнд байр сууриа ахиулахыг эрмэлзэж ирсэн

Анхаарах асуудал:

- Хамтын гэрээний хэрэгжилтийг хангахад анхаарах, ОУ-ын ЭЗС-тай цахим уулзалт, сургалтад багш, оюутнуудыг оролцуулах,

Зөвлөмж:

- Эм зүйн сургуулийг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөхүйц хэмжээнд хүргэх, гадаад оюутан суралцах нөхцлийг хангах төлөвлөгөөг боловсруулан, үе шаттай хэрэгжүүлэх
- Төгсөгчдийн чанар, чансаад үнэлгээ хийх, олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн эм зүйн сургуулиудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх

ЕРӨНХИЙ ЗӨВЛӨМЖ

1. Ойрын ирээдүйд тус сургуулийн төгсөгчид Монгол улсын эм хангамжийн салбарт ажиллагсдын дийлэнх болох төлөвтэй байгаа нь төгсөгчдөд төвигдах чанарын шаардлагыг ихээхэн нэмэгдүүлж байгаа төдийгүй хөрвөх чадвартай мэргэжилтэн бэлтгэх хэрэгцээ үүсч байгааг онцлон анхаарч мэргэжилтний загварыг улсын хэмжээнд авч үзэж хөтөлбөрийг улам боловсронгуй болгох Хөтөлбөрийн зарилгод “... **Нийгмийн хэрэгцээ шаардлагыг бүх талаараа хангасан эм зүйчдийг бэлтгэн гаргана**” гэсэн боловч ерөнхийдөө Эм зүй-менежер болон бэлтгэж байна. Цаашид эмийн химич, эмийн технологич, биотехнологич бэлтгэх шаталсан сургалтын бодлого боловсруулж хэрэгжүүлэхэд үйл ажиллагаа, хөтөлбөрийн агуулгаа хөгжүүлэх
2. Өөрийн хөтөлбөрийн гол онцлог болсон 8 од бүхий цогц чадамжтай мэргэжилтэн бэлтгэх зорилтоо сайтар хөгжүүлэн, хөтөлбөрийн агуулгыг эмнэлгийн хэрэгсэл, оношлуур, эмийн сангийн мерчиндайзинг, эмчилгээний гоо сайхны бараа, бүтээгдэхүүний чиглэлээр баяжуулах
3. Эрдмийн зэрэг, цолтой багш нарын тоог улам нэмэгдүүлэх талаар хийж буй ажил үйл ажиллагаагаа эрчимжүүлэх
4. Сургууль, улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжлийн сурах бичиг, гарын авлагын тоог нэмэгдүүлэх
5. Сургалтын ба эрдэм шинжилгээний өндөр хүчин чадалтай тоног төхөөрөмж бүхий орчин үеийн лабораторитой болох, эрдэм шинжилгээний ба сургалтын лабораторийг хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлэх, санхүүжилтийг тасралтгүй өсгөх
6. Хөтөлбөрийн агуулгыг гадаад хамтын ажиллагаатай сургуулиудынхтай ижил түвшинд хүргэж хөгжүүлэлт хийх, сурталчилгаа - маркетингийн үйл ажиллагаагаа гадаадын улс оронд гаргах, гадаадаас оюутан элсүүлэн суралцуулах бэлтгэл хангах
7. Багш нарыг хөгжүүлэх зорилгоор хэрэгжүүлж байгаа эдийн засгийн хөшүүргийг жилээс жилд өсгөн нэмэгдүүлэх, багш нарын ажлын үр дүн бүтээл, туурьвалтай нь нягт холбоотой авч үзэж байх
8. Оюутанд зориулсан аливаа үйлчилгээний санхүүжилтийг цаашид жил бүр тогтвортой өсгөх

ДУГНЭЛТ

Шалгуур		Бүрэн хангасан (2)	Хэсэгчлэн хангасан (1)	Хангааг үй (0)	Үндэслэл, шалтгаан
1	Хөтөлбөрийн төлөвлөлт	3	-	-	
2	Сургалтын үйл ажиллагаа	3	-	-	
3	Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, нөөц	3	-	-	
4	Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	5	-	-	
5	Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	5	-	-	
6	Багшлах үйл ажиллагаа	4	-	-	
7	Чанарын үнэлгээ, баталгаажилт	3	-	-	
	Нийт	26		-	
Дүгнэлт		Бүрэн хангасан			

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг Эм зүйн шинжлэх ухааны их сургуулийн Эм зүйн сургуулийн “Эм зүй” бакалаврын хөтөлбөрийг БМИУЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ерөнхий шалгуур шаардлагад нийцэж байгаа тул “ШАЛГУУРЫГ БҮРЭН ХАНГАСАН” гэж дүгнэж байна.

Шинжээчийн багийн дүгнэлтийг Эрүүл мэндийн чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

Шинжээчийн багийн ахлагч Г.Чойжамц

Шинжээчийн багийн гишүүн С.Гаадулам

Шинжээчийн багийн гишүүн..... С.Аюурбуниа

IV. Ярилцлагад оролцогчдын нэрс

Оюутнуудын төлөөлөл

№	Оюутны нэрс	Курс	Сонгосон байдал	Утас
1	Э.Очирбат	5	Ховд аймаг	95598783
2	Ц.Амарзаяа	5	Сэлэнгэ аймаг	9955-3908
3	Ч.Бадмаараг-Алтай	5	УБ хот	88943093
4	Д.Хишигдэлгэр	4	Ховд аймаг	94141441
5	Г.Идэрцогт	4	Дархан-Уул аймаг	88124822
6	Б.Болор-Оюун	4	УБ хот	88083113
7	Т.Нургүл	3	Ховд аймаг	99433104
8	Н.Ононмөрөн	3	Архангай аймаг	95299089
9	Н.Намуунтуяа	3	УБ хот	80516021
10	Н.Солонго	3	Ховд аймаг	99435307
11	Б.Энхбаяр	2	Орхон аймаг	86681774
12	Б.Бүжинлхам	2	Орхон аймаг	95692960
13	Б.Оюунгэрэл	1	УБ хот	80825156
14	Б.Мөнх-Эрдэнэ	1	Баянхонгор аймаг	88330243
15	С.Анужин	1	УБ хот	94969184

Багш нарын нэрс

№	Овог нэрс	Албан тушаал	Ажил асан жил	Заадаг хичээл	Утас
1	Б.Цэрэндолгор	Эм зүйн удирдлага, технологийн тэнхимийн эрхлэгч	14	Эм, эмнэлгийн бараа судлал, Эмийн үйлдвэрийн технологи-3	88823311
2	Х.Баярмаа	Эм судлал клиник эм зүйн тэнхимийн эрхлэгч	5	Эмийн эмчилгээ-3, Эмнэлзүйн эм зүй-1, Эмийн эмчилгээ-1	99239476
3	Д.Бадрал	Ерөнхий эрдмийн тэнхимийн эрхлэгч	20	Биологи, Ургамал судлал	99099947
4	Г.Азжаргал	Эмийн хими, Эмийн ургамал судлалын тэнхимийн багш	6	Эмийн хими-1, Эмийн хими-2	88091421
6	Э.Наранчимэг	Эмийн үйлдвэрийн инженер технологийн тэнхимийн багш	12	Эмийн технологи-1.1, Эмийн технологи-1.2, Эмийн үйлдвэрийн технологи-3	99129787
7	Ц.Лхагвасүрэн	Эм судлал клиник эм зүйн тэнхимийн багш	5	Эм судлал-1, Эм судлал-2	88058658
8	М.Сайнгэрэл	Биоанагаах эмнэлзүйн тэнхимийн багш	5	Физиологи, Эмгэг физиологи	99178575
9	Э.Цэвээнсүрэн	Ерөнхий эрдмийн тэнхимийн эрхлэгч	5	Анагаахын хими-2, Биохими	88189986
10	Г.Бямбасүрэн	Эм зүйн удирдлага, технологийн тэнхимийн эрхлэгч	3	Эм зүйн албаны бүртгэл, тайлан, тооцоо	88980842

Ажил олгогчдын төлөөлөл

№	Нэрс	Байгууллага, албан тушаал	Утас
1	И.Балжинням	Эм холбоо	99098752
2	У.Шижирбаатар М.Адасхан	"Монос" ХХК-Хөдөө орон нутаг хариуцсан менежер	99195917
3	Б.Болорчимэг	Хөвсгөл аймаг Нэгдсэн эмнэлгийн Эм Зүйн албаны дарга	99362919
4	Л.Алтанцогт	"Монос УБ" ХХК, гүйцэтгэх захирал	99117102
5	Гансаруул	Улсын нэгдсэн 2 төв эмнэлэг	99169341
6	Б.Энхзаяа	Монос фарм, Бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн албаны дарга	88114862
7	Ц.Эрдэнэбат	"Тимус фарм" ХХК, эмч төлөөлөгч	99100253
8	Ш.Саранчимэг	"Монос фарм трейд" Эмийн маркетингийн алба, Ахлах менежер	99242297
9	Ш.Хонгорзул	МЭИКонцерн,	88025150
10	Д.Туул	"Ази" ХХК (Эмийн сан хариуцсан)	99281609
11	Р.Мөнхцэцэг	"Цомбо" ХХК, Захирал	99116102

Төгсөгчдийн төлөөлөл

№	Овог нэрс	Төгссөн он	Байгууллага, албан тушаал	Утас
1	А.Чинсүх	2014	"Монос Фарм" ХХК үйлдвэрийн менежер	80018514
2	С.Бат-Очир	2014	"КРКА" ХХК, эм зүйч төлөөлөгч	95952768
3	Б.Долгорсүрэн	2015	"Монос фарм трейд" ХХК, эм зүйч менежер	80010789
4	Х.Уранчимэг	2015	Улсын 3-р төв эмнэлэг, клиник эм зүйч	94732469
5	Г.Гантуяа	2015	"Ази фарм" ХХК	99544664
6	Б.Баярмаа	2016	"Монос трейд" ХХК, Эм зүйч менежер	99070492
7	Э.Энхцэцэг	2017	"Архон" ХХК, Эм зүйч төлөөлөгч	99991345
8	Ч.Тунгалаг	2018	"Гайхамшигт тун" ХХК, Захирал	99070524
9	Т.Дэлгэржаргал	2019	ХУД, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын байцаагч	99159191
10	А.Түвшинжаргал	2019	"Ансут" ХХК, эм зүйч	99093465

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал
/албан бичгийг оруулах/



Улаанбаатар хот, zip code-18130
Сонгинохайрхан дүүрэг-20
Сонсголонгийн Зам Гудамж 4/А
Утас: 70174640
Факс: 976-70174640
Website: www.monos.edu.mn
E-mail: university@monos.mn

2020.12.28 № 282
танай _____ № _____ -т

**БОЛОВСРОЛ ШИНЖЛЭХ УХААНЫ
ЯАМ-БОЛОВСРОЛЫН МАГАДЛАН
ИТГЭМЖЛЭЛИЙН ҮНДЭСНИЙ
ЗӨВЛӨЛ-д**

Хариу хүргүүлэх тухай

Эм Зүйн Шинжлэх Ухааны Их Сургууль нь Боловсролын Магадлан Итгэмжлэлийн Үндэсний Зөвлөлөөр Эм зүй хөтөлбөрийг хоёр дахь шатанд магадлан итгэмжлүүлэх шинжээчийн тайланг хүлээн авч, уншиж танилцсан. Шинжээчийн тайланг мэргэжлийн салбар зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх саналыг хүргүүлж байна.

Хүндэтгэсэн:

ЗАХИРАЛ, МАУА-ИЙН ГИШҮҮН-АКАДЕМИЧ
ЭЗҮ-НЫ ДОКТОР, ПРОФЕССОР



Л.ЦЭРЭНДУЛАМ

ҮІ. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

Мэргэжлийн зөвлөлийн хуралдаан (огноо)
[Мэргэжлийн зөвлөлийн хэлэлцүүлгийн дүгнэлт]